



ДОРНОД АЙМАГ “АДУУНЧУЛУУН” ХУВЬЦААТ КОМПАНИЙН ТӨЛӨӨЛӨН УДИРДАХ ЗӨВЛӨЛ

2017 оны 08 дүгээр
сарын 03-ны өдөр

Дугаар 01

Чойбалсан хот.

Адуунчулуун ХК-ийн 2016 оны санхүүгийн тайлант жил дууссантай холбогдуулан хувьцаа эзэмшигчдийн хурлыг хуралдуулах тухай **ШИЙДВЭРЛЭХ** нь:

1. “Хувьцаат компанийн хувьцаа эзэмшигчдийн хурлын зар хүргэх тухай” журмын дагуу “Адуунчулуун” ХК-ийн хувьцаа эзэмшигчдийн ээлжит хурлыг 2017 оны 4-р сарын 13-ний өдрийн 14.00 цагт тус компанийн хурлын танхимд зарлан хуралдуулсугай.

2. Хурлаар хэлэлцэх асуудал:

- А. Компанийн 2016 оны үйл ажиллагааны тайлан, санхүүгийн тайлан
- Б. Компанийн үйл ажиллагааны болон санхүүгийн тайлангийн талаарх ТУЗ-ийн дүгнэлт, нэгж хувьцаанд ногдол ашиг хувиарлах талаар
- В. Компанийн 2017 оны төлөвлөгөө
- Г. ТУЗ-ийн гишүүд, хараат бус гишүүдийг сонгох

3. Хуралд оролцох эрхтэй хувьцаа эзэмшигчдийн нэрсийн жагсаалт гаргах бүртгэлийн өдөр 2017 оны 3-р сарын 24-ны өдөр болно.

4. Хурал хуралдуулах тухай хувьцаа эзэмшигчдэд мэдэгдэх өдөр: өглөөний сонин, өдрийн сонингийн 3-р сарын 09, 3-р сарын 24-ны өдрийн дугааруудаар зарласугай.

5. Хуралд бэлтгэх явцад хувьцаа эзэмшигчдийн танилцаж болох баримт: компанийн 2016 оны санхүүгийн тайлан

6. Хуралд оролцохоор биеэр ирсэн хувьцаа эзэмшигч саналын хуудсаар хэлэлцэж буй асуудлуудад саналаа өгнө. Саналын хуудсыг бөглөхдөө хэлэлцэх асуудал тус бүрт өөрийн эзэмшиж буй хувьцааны тоогоор саналаа өгч, гарын үсэг зурж баталгаажуулна. Саналын хуудас хүлээн авах сүүлчийн өдөр 4-р сарын 13-ний өдөр байна.

7. ХЭХурлын даргаар М.Шинэтогтох, тооллогын комиссын дарга Ж.Мөнхсайхан, тооллогын комиссын гишүүд Б.Алтанцэцэг, О.Гангамөрөн нарыг томилсугай.

“Хувьцаат компанийн хувьцаа эзэмшигчдийн хурлын зар хүргэх тухай”
журмын дагуу хурлын зарыг хүргэж, хурал зохион байгуулахыг ТУЗ-ийн нарийн
бичгийн дарга /Б.Тэнгис/-д үүрэг болгосугай.

ТУЗ-ИЙН ДАРГА

НАРИЙН БИЧГИЙН ДАРГА



М.ШИНЭТОГТОХ

Б.ТЭНГИС